

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2026/5/НА-СТА-ОНА

Цахим www.audit.mn Дорноговь аймаг 2026 он	хуудас:	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: З.Ундармаа Утас: 8901-1289 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com Ахлах аудитор/Аудитор: Т.Золбоо Утас: 9111-1254 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com
---	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.03.13 № 1 - 6/313

танай _____ -ны № _____ -т

Г ДАГШИН-ЭРДЭНЭ ОНӨААТҮГ-ЫН Г
ЗАХИРАЛ Ц.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

442505289

Бусад асуудлын хэсэг

2025 онд гүйцэтгэхээр холбогдох газраар батлуулсан эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл 90.4 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	77,550,094.78	67,281,149.51
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,474,016.83	1,415,540.93
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,474,016.83	1,415,540.93
31210	Төгрөг	18,474,016.83	1,415,540.93
31213	Арилжааны банк дахь харилцах	18,474,016.83	1,415,540.93
33	АВЛАГА	2,296,071.62	4,823,102.25
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	2,296,071.62	4,823,102.25
35	БАРАА МАТЕРИАЛ	56,780,006.33	61,042,506.33
35400	Хангамжийн материал	53,040,006.33	55,902,506.33
35420	Аж ахуйн материал	53,040,006.33	55,902,506.33
35600	Мал амьтад	3,740,000.00	5,140,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	375,100,845.63	437,528,327.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	375,100,845.63	437,528,327.73
39200	Биет хөрөнгө	343,004,845.63	405,432,327.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	282,431,486.00	282,431,486.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(66,633,710.92)	(78,080,454.35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,485,000.00	45,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(113,485,000.00)	(9,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	109,257,371.18	83,688,906.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(80,011,943.92)	(39,910,884.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,042,812.00	37,882,360.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(48,392,448.11)	(14,841,654.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	161,024,094.00	146,651,344.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(69,712,814.60)	(48,388,774.70)
39300	Биет бус хөрөнгө	32,096,000.00	32,096,000.00
39301	Програм хангамж	2,000,000.00	2,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,096,000.00	30,096,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	452,650,940.41	504,809,477.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	16,074,257.57	15,834,483.55
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,124,617.83	1,884,843.81
41300	Өглөг	2,124,617.83	1,884,843.81
41360	Бусад өглөг	2,124,617.83	1,884,843.81
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	2,124,617.83	1,884,843.81
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,949,639.74	13,949,639.74
42200	Урт хугацаат зээл	13,949,639.74	13,949,639.74
42210	Төгрөг	13,949,639.74	13,949,639.74
42242	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	13,949,639.74	13,949,639.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	436,576,682.84	488,974,993.69
51	Засгийн газрын хувь оролцоо	436,576,682.84	488,974,993.69
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,089,477,842.00	964,641,175.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(652,901,159.16)	(475,666,181.31)
51210	Өмнөх үеийн үр дүн	(578,562,492.86)	(421,023,492.16)
51220	Тайлант үеийн үр дүн	(74,338,666.30)	(54,642,689.15)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	452,650,940.41	504,809,477.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	142,239,365.19	187,860,548.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142,239,365.19	187,860,548.90
120	Нийтлэг татварын бус орлого	142,239,365.19	187,860,548.90
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	168,040,362.09	211,777,016.44
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	25,800,996.90	23,916,467.54
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	216,578,031.49	242,503,238.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	216,578,031.49	242,503,238.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,578,031.49	242,503,238.05
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	216,578,031.49	242,503,238.05
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	216,578,031.49	242,503,238.05
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(74,338,666.30)	(54,642,689.15)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(74,338,666.30)	(54,642,689.15)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	179,743,435.50	247,270,017.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	179,743,435.50	247,270,017.00
120	Нийтлэг татварын бус орлого	179,743,435.50	247,270,017.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,417,512.20	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,417,512.20	-
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	145,598,650.60	247,270,017.00
120017	Татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/	17,727,272.70	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	223,045,661.50	264,328,492.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	223,045,661.50	264,328,492.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	223,045,661.50	264,328,492.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	102,301,235.00	133,915,073.68
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	102,301,235.00	133,915,073.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,668,545.23	-
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	19,668,545.23	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,918,771.45	12,495,932.08
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	36,918,771.45	12,495,932.08
2104	Хангамж, бараа материалын зардал	27,695,898.59	54,389,720.70
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	11,370,059.97	2,666,272.70
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	16,325,838.62	51,723,448.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,461,211.23	63,527,766.44
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	27,278,326.97	15,491,483.53
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	217,200.00	-
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	8,965,684.26	48,036,282.91
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(43,302,226.00)	(17,058,475.90)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	35,312,659.09	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,312,659.09	-
2200	Дотоод эх үүсвэрээр	35,312,659.09	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,312,659.09	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(35,312,659.09)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(78,614,885.09)	(17,058,475.90)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,088,901.92	18,474,016.83
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,474,016.83	1,415,540.93

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,089,477,842.00	-	(578,562,492.86)	510,915,349.14
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,089,477,842.00	-	(578,562,492.86)	510,915,349.14
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(74,338,666.30)	(74,338,666.30)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,089,477,842.00	-	(652,901,159.16)	436,576,682.84
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,089,477,842.00	-	(652,901,159.16)	436,576,682.84
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,089,477,842.00	-	(652,901,159.16)	436,576,682.84
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	231,877,667.00	231,877,667.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(231,877,667.00)	-	-	(231,877,667.00)
17	Өмчид гарсан өөрчлөлт	107,041,000.00	-	-	107,041,000.00
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(54,642,689.15)	(54,642,689.15)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	964,641,175.00	-	(475,666,181.31)	488,974,993.69

2.5 Эдийн засгийн зорилтот түвшин

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Нийт орлого	234,142,200.00	211,777,016.00	22,365,184.00	90.4%
Сувилалын орлого	205,342,200.00	186,147,659.00	19,194,541.00	90.7%
Аялал жуулчлал	9,600,000.00	15,369,757.00	(5,769,757.00)	160.1%
Түрээс	3,600,000.00	2,910,000.00	690,000.00	80.8%
Байгальтай харьцсан	6,100,000.00	1,820,000.00	4,280,000.00	29.8%
Хог зөөврийн санхүүжилт	9,500,000.00	5,529,600.00	3,970,400.00	58.2%
Нийт зардал	230,595,509.00	266,419,705.00	(35,824,196.00)	115.5%
Цалин	135,686,859.00	141,295,621.00	(5,608,762.00)	104.1%
НДШ	16,960,857.00	11,987,786.00	4,973,071.00	70.7%
Шатхуун	8,384,000.00	2,391,454.00	5,992,546.00	28.5%
Цахилгаан	6,936,504.00	8,037,173.00	(1,100,669.00)	115.9%
Дулаан	5,131,805.00	4,458,759.00	673,046.00	86.9%
Томилолт	330,000.00	-	330,000.00	0.0%
татвархураамж	4,669,349.00	2,045,181.00	2,624,168.00	43.8%
Хог хаягдээвөр	3,600,000.00	5,110,000.00	(1,510,000.00)	141.9%
Хоол хүнс бараа материал	20,581,225.00	23,916,467.00	(3,335,242.00)	116.2%
Даатгал	260,370.00	-	260,370.00	0.0%
Бичиг хэргийн зардал	337,000.00	118,636.00	218,364.00	35.2%
Цэвэр бохир цэвэрлэгээ	300,000.00	3,562,404.00	(3,262,404.00)	1187.5%
Сэлбэгэ хэрэгсэл машины засвар үйлчилгээ	2,000,000.00	18,865,922.00	(16,865,922.00)	943.3%
ДДШ интернет холбоо	600,000.00	231,000.00	369,000.00	38.5%
Эм хангамж	487,500.00	535,785.00	(48,285.00)	109.9%
Элэгдэл хорогдол	24,330,040.00	43,863,517.00	(19,533,477.00)	180.3%
Нийт ашиг алдагдал	3,546,691.00	(54,642,689.00)	58,189,380.00	-1540.7%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2 зөрчил илрүүлж 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Төсвийн тухай хуулийн 8.9.8.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ гэж заасны дагуу 2025 оны санхүүгийн тайланг хугацаанд нь хүргүүлээгүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 05/05 тоот тогтоолоор тус байгууллагын ашиглалтын хугацаа дууссан боловч үргэлжлүүлэн ашиглаж байгаа 2 нэр төрлийн тээврийн хэрэгсэл, 42 нэр төрлийн тоног төхөөрөмжид дахин үнэлгээ хийсэн. Тус дахин үнэлгээтэй холбоотой өсөлт бууралтыг УСНББОУС-17: Үндсэн хөрөнгийн дагуу “Дахин үнэлгээний нэмэгдэл” данс ашиглалгүй “Засгийн газрын хувь оролцоо” дансыг өөрчилсөн байна.

Өгсөн зөвлөмж: Тус дахин үнэлгээтэй холбоотой өсөлт бууралтыг УСНББОУС-17: Үндсэн хөрөнгийн дагуу “Дахин үнэлгээний нэмэгдэл” дансанд бүртгэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Санхүүгийн тайлан хоцроосон.	1	-				-			1	-
2	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой өсөлт бууралтыг УСНББОУС-17: Үндсэн хөрөнгийн дагуу “Дахин үнэлгээний нэмэгдэл” данс ашиглалгүй “Засгийн газрын хувь оролцоо” дансыг өөрчилсөн	1	-					1	-		
	Дүн	2	-				-	1	-	1	-